

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

№ 19/35

Улаанбаатар хот

Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, оруулсан өөрчлөлтийн дагуу хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.19, 9.11 дэх заалт, 19 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 19/22 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн шинэчилсэн төсөвтэй уялдуулан Компанийн “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-ний 2.1, 2.2, 3.1 дүгээр заалтуудыг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасны дагуу өөрчилсүгэй.
2. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-ний өөрчлөлтийн 3.1-т заасан хэмжээний хүрээнд эх үүсвэр татан төвлөрүүлэх, хэлэлцээр хийх, Зээлийн гэрээ, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ болон холбогдох бусад гэрээ, хэлцлийг байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолд заасан хэмжээний хүрээнд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, холбогдох гэрээ, хэлцэл байгуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг баримтлан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хүрээнд байгуулсан эх үүсвэрийн гэрээ, хэлцэл, тэдгээрийн нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд тухай бүр эргэн танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

...../О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

...../В.БАЯРСАЙХАН/

...../MATHEW WELCH/

...../С.БОРГИЛ/

...../Ч.НОМИН/

...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/

...../Н.ЦЭВЭГМИД/

...../Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

...../С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

№ 19/36

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20, 9.11, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.4, 20.5 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.8, 11.12 дахь заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 19/12 тоот тогтоолын Хавсралтаар батлагдсан “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-ны дагуу Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Анд Системс ХХК-тай байгуулсан 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ЗГ19/13 тоот 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийн үнийн дүнтэй, 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ЗГ19/14 тоот 114,000,000 (нэг зуун арван дөрвөн сая) төгрөгийн үнийн дүнтэй болон 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн ЗГ19/16 тоот 1,500,000 (нэг сая таван зуун мянга) хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн үнийн дүн бүхий Зээлийн гэрээнүүдийг байгуулсан үйлдлийг зөвшөөрч, баталсугай.

ТУЗ-ийн гишүүд:

ЛЭНДМН ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

...../С.БОРГИЛ/

...../Ч.НОМИН/

...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/

...../С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

№ 19/37

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх,
зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.5, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.20, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Анд Системс ХХК-аас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж, зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.

Санхүүжилтын төрөл	Зээл
Зээлийн хугацаа	36 сар хүртэл хугацаатай
Зээлийн хүү	Анд Системс ХХК-ийн татсан эх үүсвэр өртөг дээр холбогдох татвар нэмж тооцсон хувь
Зээлийн хэмжээ	7,000,000,000 (долоон тэрбум) төгрөг хүртэл
Зээлийн хүү төлөх нөхцөл	Анд Системс ХХК-ийн татсан эх үүсвэрийн хүү төлөх нөхцөлийн дагуу
Зээлийн эргэн төлөлт	Анд Системс-ийн санхүүжилтын эх үүсвэрийн эргэн төлөх нөхцөлийн дагуу
Барьцаа	Барьцаагүй

2. Зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
3. Анд Системс ХХК-тай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтийн нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолыг баталсантай холбоотойгоор ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 19/29 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

ЛЭНДМН ББСБ ХК



lendmn

УЛААНБААТАР ХОТ
5039754 ул.1118267206

..... /С.БОРГИЛ/

..... /Ч.НОМИН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

№ 19/38

Улаанбаатар хот

Хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.19, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-нд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Райнос Эссет Менежмент Монгол” ХХК, түүний үүсгэн байгуулагч бөгөөд холбогдох эрх бүхий байгууллагын бүртгэл, зөвшөөрөл бүхий хөрөнгө оруулалтын сантай хамтран ажиллаж нийт 4,000,000.00 (дөрвөн сая) АНУ-ын долларын санхүүжилтын эх үүсвэр татах буюу энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан нөхцөлийн хүрээнд Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ болон холбогдох бусад гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотойгоор гадаад валютын эх үүсвэрийг зохистой түвшинд, үр ашигтай удирдах, гадаад валютын эрсдэлээс хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, шаардлагатай тохиолдолд холбогдох саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулан, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороонд тогтмол тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

...../О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

...../В.БАЯРСАЙХАН/

...../MATHEW WELCH/

...../С.БОРГИЛ/

...../Ч.НОМИН/

...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/

...../Н.ЦЭВЭГМИД/

...../Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

...../С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

№ 19/39

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай


Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.20 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. LendMN аппликейшнаар үзүүлэх үйлчилгээний төрөл, цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Анд Системс ХХК нь өөрийн болон гуравдагч этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг LendMN аппликейшнаар дамжуулан хэрэглэгчдэд санал болгох, түүний төлбөр тооцоог ЛэндМН ББСБ ХК-иар гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор байгуулсан энэхүү тогтоолын Хавсралтад заасан гэрээнүүдийг хүчин төгөлдөр болохыг хүлээн зөвшөөрч баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан асуудлаар “Анд Системс” ХХК-тай Хамтран ажиллах гэрээ болон холбогдох бусад гэрээ, хэлцлүүдийг байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга) –д зөвшөөрсүгэй.


ТУЗ-ИЙН ГИШҮҮД:




...../С.БОРГИЛ/



...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/



...../Ч.НОМИН/



...../С.ЭНХ-АМГАЛАН/